

ДААТГАЛЫН МЭДЭЭ

2009 ОНЫ 12 ДУГААР САР

1. САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ:

Даатгалын компаниудын 2009 оны 3 дугаар сараас 12 дугаар сар хүртэлх даатгалын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийг харуулбал:


Ердийн даатгалын компаниудын хувьд :

/сая төгрөгөөр/

| № | Үзүүлэлт | 2009-III | 2009-IV | 2009-V | 2009-VI | 2009-VII | 2009-VIII | 2009-IX | 2009-X | 2009-XI | 2009-XII |
|---|---|-----------|-----------|----------|-----------|-----------|-----------|----------|-----------|---------|----------|
| 1 | Даатгалын нийт хураамж | 1 508,10 | 2 843,70 | 1 782,80 | 2 838,80 | 1 853,90 | 2 148,00 | 1 687,80 | 1 598,50 | 1 178,1 | 2 227 ,6 |
| 2 | Олгосон нийт нөхөн төлбөр | 403,90 | 417,40 | 439,70 | 411,50 | 605,90 | 365,00 | 494,00 | 392,80 | 813,1 | 588 ,7 |
| 3 | Давхар даатгалд төлсөн хураамж | 638,50 | 543,30 | 3 864,30 | 182,20 | 33,70 | 785,30 | 755,70 | 613,20 | 217,6 | 369 ,0 |
| 4 | Байгуулсан даатгалын гэрээний тоо /ширхэг/ | 13 586 | 39 878 | 16 684 | 12 321 | 7 779 | 4 689 | 4 708 | 5 201 | 4 347 | 8 172 |
| 5 | Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн | 63 747,10 | 45 803,80 | 7 425,60 | 24 565,00 | 99 370,10 | 3 142,30 | 7 140,00 | 18 000,00 | 5 500,0 | 27 709,3 |
| 6 | Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн | 95,60 | 50,00 | 46,80 | 21,20 | 101,80 | 45,00 | 70,40 | 43,30 | 250,0 | 27,1 |

2009 оны 12 дугаар сарын даатгалын хураамжийн орлого 11 дүгээр сарынхаас 1,89 дахин нэмэгдсэн бол олгосон нөхөн төлбөр 27,6 хувиар буурсан урвуу үзүүлэлттэй байна. Даатгалын хураамжийн орлого 4 дүгээр сард хамгийн өндөр дүнтэй байгаа бол 11 дүгээр сард хамгийн бага дүнтэй байна. Харин даатгалын нөхөн төлбөрийн дүн 10 дугаар сард хамгийн бага байсан бол 11 дүгээр сард хамгийн өндөр байна.

Даатгалын хураамжийн орлого болон нөхөн төлбөрийн харьцаа




Ердийн даатгалын компаниудын 2009 оны 12 дугаар сард олгосон нөхөн төлбөрүүдээс хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийг “Монгол даатгал” ХХК нь “Голомт банк”-ны даатгалын гэрээний нөхөн төлбөрт 27.1 сая төгрөг олгосон байна. 2009 оны 3 дугаар сараас 12 дугаар сар хүртэл ердийн даатгалын компаниудын олгосон нөхөн төлбөрүүдээс хамгийн өндөр дүнтэй нь “Монгол даатгал” ХХК-ийн “Вагнер Ази тоног төхөөрөмж” ХХК-ийн Хүнд болон тусгай зориулалтын машин механизмын даатгалын гэрээний нөхөн төлбөрт олгосон 250,0 сая төгрөгийн нөхөн төлбөр байна.

Урт хугацааны даатгалын компанийн хувьд :

| № | Үзүүлэлт | /сая төгрөгөөр/ | | | | | | | | | |
|---|---|-----------------|---------|---------|---------|----------|-----------|---------|----------|---------|----------|
| | | 2009-III | 2009-IV | 2009-V | 2009-VI | 2009-VII | 2009-VIII | 2009-IX | 2009-X | 2009-XI | 2009-XII |
| 1 | Даатгалын нийт хураамж | 1,4 | 4,5 | 1,1 | 1,6 | 0,5 | 3,6 | 5,3 | 11,1 | 71,4 | 8,5 |
| 2 | Олгосон нийт нөхөн төлбөр | 0,6 | 0,0 | 0,0 | 0,3 | 0,5 | 0,8 | 0,6 | 1,0 | 0,7 | 6,1 |
| 3 | Давхар даатгалд төлсөн хураамж | 0,0 | 0,0 | 0,0 | 0,0 | 0,0 | 3,8 | 0,0 | 3,8 | 0,0 | - |
| 4 | Байгуулсан даатгалын гэрээний тоо /ширхэгээр/ | 5 гэрээ | 3 гэрээ | 6 гэрээ | 4 гэрээ | 12 гэрээ | 8 гэрээ | 9 гэрээ | 19 гэрээ | 3 гэрээ | 3 гэрээ |

| | | | | | | | | | | | |
|---|---|------|------|------|------|------|-------|------|------|------|------|
| 5 | Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн | 50,0 | 50,0 | 51,0 | 50,0 | 15,0 | 100,0 | 30,0 | 20,0 | 30,0 | 50,0 |
| 6 | Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн | 0,4 | 0,0 | 0,0 | 0,2 | 0,5 | 0,5 | 0,5 | 1,0 | 0,4 | 5,0 |

Даатгалын хураамжийн орлого болон нөхөн төлбөрийн харьцаа /сая төгрөгөөр/



“Нэйшнл лайф даатгал” ХХК-ийн даатгалын хураамжийн орлогыг 3 дугаар сараас 12 дугаар сарын байдлаар авч үзэхэд 2009 оны хувьд хамгийн өндөр даатгалын хураамжийн орлогыг 11 дүгээр сард буюу 71.4 сая төгрөгийн даатгалын хураамжийн орлогыг төвлөрүүлсэн байна. Харин олгосон нөхөн төлбөр 2009 оны хувьд 12 дугаар сард хамгийн өндөр буюу 6,1 сая төгрөгийг хугацаат амьдралын даатгалын гэнэтийн осол, эмнэлгийн мөнгө нэмэлт нөхцөлөөр нөхөн төлбөрт олгосон байна.

12 дугаар сард 3 байгууллагатай “Хугацаат амьдралын даатгал”-ын гэрээг байгуулж, нийт 761 хүнийг даатгалд хамруулж ажилласан байна.